

ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЛБА ХААГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГАА

PROVIDING SAFETY FOR PRISON GUARDS

Ч.Энхбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 7051 дүгээр дамжааны магистрант, хошууч
Enkhbayar Ch.

Postgraduate student, Education and Research Unit № 403, University of Internal Affairs of Mongolia, Major

Хураангуй: Аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны ерөнхий ойлголтыг судлах замаар хувь хүн болон байгууллагын аюулгүй байдлын ойлголтыг тодорхойлж, цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах ажиллагааны зүй тогтол, мөн чанарыг тодорхойлно.

Abstract: By studying the general concept of the science of security studies, the concept of individual and organizational security will be determined, and the nature and pattern of security operations in the detention center will be determined.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, алба хаагч, эрсдэл, аюул, урьдчилан сэргийлэх.

Key words: Security, officers, risk, danger, prevention.

Удиртгал

Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь оролцогчдын эрх зүйн байдал болон уг ажиллагааг гүйцэтгэх практик онцлог талаасаа ихээхэн анхаарал татаж байдаг эрх зүйн чухал салбар. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь хүний эрхийг хамгаалах, ахуйн нөхцөлийг дээшлүүлэх, түүнчлэн цагдан хорих байранд хүний эрхийн зөрчил гаргахгүй байх шаардлага нь нилээд өндөр хэмжээнд тавигдах болсон бөгөөд цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах асуудлыг боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Эрх зүйн орчны хувьд “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” (Төрийн мэдээлэл эмхэтгэл 17 дахь хэвлэл, 2012)-ийг батлан гаргасан нь цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагааны талаарх дагнан гаргасан анхны бие даасан хууль болсон төдийгүй цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах ажиллагааны нэг дэвшил гэж үзэж болно.

Түүхэн хөгжлийн хувьд цагдан хорих ажиллагаанд холбогдох анхдагч эх сурвалж нь 1931 оны “Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль”, 1966 онд

батлагдсан “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль”-д бүлэг, заалт хэлбэрээр тусч байсан боловч энэ нь 1981 оны хууль бусад дараа, дараагийн хуулиудад тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорихтой холбогдсон хүний эрхийн хамгийн эмзэг ажиллагааг хуулиар бус Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайд, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын даргын тушаал /тухайн үедээ нууцын зэрэглэлтэй гарч байсан/-аар батлагдсан заавар дүрмээр зохицуулж байв. Энэ байдал нь тухайн асуудлыг хуулиас гадуур орхигдуулан хууль дээдлэх ёсыг алдагдуулсан, дахин хуулиар зохицуулах шаардлагатайг харуулж байсан байна.

Иймд цаашид цагдан хорих байрны аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, эрх зүйн хэм хэмжээнд тусгах байдлаар цогц арга хэмжээ авах нь хүний эрх, эрх чөлөөг хангах, байгууллагын үйл ажиллагааны зорилго зорилт хангагдах чухал ач холбогдолтой.

Үүний тулд аюулгүй байдлын ойлголтыг тодруулан судалж цагдан хорих үйл ажиллагааны онцлогт тохируулах тодорхойлох хэрэгтэй.

Үндсэн хэсэг



Урьдчилан сэргийлэх



МОНГОЛ УЛСЫН
ХАМГААГАХ
ХУУЛЬ

Аюул гэдэг нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд сөнөөх, сүйтгэх шинж чанар бүхий объект, хүчин зүйлсийн зүгээс хүн, байгаль, ямар нэгэн зүйлд хор хохирол учруулах магадлалын тухай ойлголт юм. Аюулын нэлээд тодорхой объектод чиглэсэн, түүнийг онилсон хэлбэрийг занал гэж үздэг. (Прохожев А.А. Общая теория национальной безопасности)

Аюул нь логикийн хувьд анхдагч ойлголт юм. Энэ нь хийсвэр, тодорхой, бодитой байж болно. Хийсвэр аюул гэдэг нь аюулгүй байдал тухайн агшинд бодитой болох нөхцөл бүрдээгүй байдлаар хязгаарлагдаж байдаг. Ийм нөхцөл бүрэлдсэн болон тухайн объектод чиглэсэн аюулын дохио өгсөн үед тодорхой аюул болно. Чиглэл, зорилготой үйл ажиллагааны үр дүнд, эсвэл хүмүүсийн бодол, эргэцүүлэлд аяндаа мэдрэгдэж, анхаарал татсан, эсвэл үнэхээр бий болоод байгаа аюул нь занал болж даамжирна. Ингэхээр аливаа аюул нь өөртөө ямар нэгэн байдлаар заналыг дагуулж байдаг ажээ. (Эрдэнэчимэг Б. Аюулгүй байдлын чиг хандлага өөрчлөлт, батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь, 10 дахь тал, 2016)

Бодит амьдрал дээр янз бүрийн аюул урьд байсан, одоо ч байгаа, цаашид байсаар байх нь тодорхой юм. Ийм учраас аюулгүй байдлын өнөөгийн агуулгыг "аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар" (Бельков О.А. Понятийно-категориальный аппарат концепции национальной безопасности, №3, стр 91, 1994) гэж тодорхойлсон байна. Хүн төрөлхтний хөгжлийн бүхий л үед хүмүүс болоод нийгэмд аюул, занал учруулж ирсэн олон төрлийн байнгын эх үүсвэр бий.

Аюул гэдэг нь англи хэлнээ "threat", орос хэлэнд "угроза", харин монгол хэлнээ "аюул" гэсэн утгаар хэрэглэж байна. Монгол хэлний тайлбар тольд "аюул" – гамшиг зовлон учруулж болох хор хөнөөлтэй юм, "занал" – занах үйлийн нэр (Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь, 60 дахь тал, 1996) (Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь, 60 дахь тал, 1996) , харин Вебстерийн (Merriam

Webster) тайлбар тольд "threat" гэдэг нь "муу зүйл, гэмтэл, эсвэл хохирол учруулах зорилгын илрэл" (www.merriam-webster.com) гэж тодорхойлсон байна. Судлаач Ч.Улаанхүү "аюул–энэ бол сөрөг үйлчлэлийн бодитой оршин тогтнож байгаа боломж, золгүй байдлыг нүүрлэхийг урьдаас мэдрэх боломж, эсхүл нүүрлэх байдал, аль нэг субъектийн ахуй амьдралд нэн чухал объектууд, байгалийн үнэт зүйлсийг сөнөөх, эсвэл тэдгээрт хор хохирол учруулж унаган төрхийг алдагдуулах, хөгжлийн зам мөрийг хаах боломж бүхий бодитой эсхүл болзошгүй үзэгдэл, үйл явц юм, занал – хэн нэгнийг таагүй байдал, гай зовлонд автагдуулахаар айлган сүрдүүлэх, амлаж андгайлах, илтээр дайсагнагч хүчний зүгээс чиглэл, зорилготой явуулж байгаа аюулын нэн илт, тодорхой, шууд хэлбэр, айдас хүйдэст автуулах замаар аль нэг харилцааны түвшинд давуу байдал олж авах үндсэн зорилготойгоор сөрөг талыг төөрөгдөлд оруулж байгаа арга хэлбэр юм" (Улаанхүү Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал, 69-70 дахь тал, 2014) гэж тодорхойлжээ.

Аюул нь олон янзын хэлбэрээр оршин тогтнож болно. Аюулын тухай орчин үеийн үзэл баримтлалд уламжлалт аюул, уламжлалт бус аюул гэж ангилж байна. Уламжлалт бус аюул гэж орчин үед гарч ирсэн шинэ аюулууд тухайлбал, терроризм (хорлон сүйтгэх ажиллагаа, хэт даврах ажиллагаа), хар тамхи, хүний наймаа, онц халдварт өвчин, далайн дээрэм, хууль бус цагаачлал, орчны аюулгүй байдал, санхүү, эдийн засаг, мэдээллийн аюулгүй байдалд нүүрлэсэн аюулыг хэлдэг болжээ. (Төмөрчулуун Г. Уламжлалт бус аюулын зарим асуудал. Монгол Улсын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ, 161 дэх тал, 2014)

Хүн төрөлхтний үүсэл хөгжил, хөгжлийн бүх үе шатад хувь хүн, нийгэм, улс орон, хамтын нийгэмлэгийн амьдрал, үйл ажиллагааны салшгүй дагуул нь аюул занал байсаар ирсэн. Аюулгүй байдлын асуудалд төдийлөн анхаарал тавьж байгаагүйгээс хүн, өрх гэр, компани, улс

орон бутран сөнөж, дайн самуун дэгдэж, гай гамшиг тарьж байв. (Хил судлал сэтгүүл, 73 дахь тал, 2015)

Аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх салбар шинжлэх ухаан тусдаа байх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэхүү салбар нь эрх зүй, сэтгэл судлал зэрэг олон жинжлэх ухааны ололт, мэдээлэлд суурилан хөгжих зүй тогтолтой ажээ.

Аюулгүй байдал судлалын ухааны үүднээс онолын хүрээнд авч үзвэл аюулгүй байдал гэдэг нь судалгааны түвшингээсээ хамааран харилцан адилгүй бүтэцтэй учраас нарийн тодорхойлоход хялбар бус юм.

Хүний онцлог чанар, түүний сэтгэхүйн ер бусын төрх, шинж, дотоод ертөнцийн онцлог байдал зэрэг нь хүн судлалын үндсэн асуудал байсаар иржээ. Аюулгүй байдлын тогтолцоонд хүний эзлэх байр суурь нь амьдралд түүний эзэлж байгаа орон зай, гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдлоос хамаарч байдаг. Ихэнх тохиолдолд аюулгүй байдлын судалгааны субъект нь хүн өөрөө байдаг ч судалгааны объект нь байгаль, техник хэрэгсэл, эд хөрөнгө, баялаг болон иргэд, нийгэм, улс гүрний бүрэн эрх, хуульчлагдсан ашиг сонирхол байх нь түгээмэл асуудал юм. Тэрчлэн тухайн хүн тодорхой нөхцөлд аюул заналын субъект болохын зэрэгцээ мөн объект ч болох тохиолдол байдаг.

Нийгмийн аливаа гишүүн бүр хэнээс ч, юунаас ч айж түгшихгүй амар тайван байх нөхцөл бүрдсэн байваас тухайн нийгэм бүхэлдээ амар тайван байх боломж бүрдэнэ гэж тэрбээр үзэж байжээ. (Бор Ж. Чулуунбат В. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс, 51 дэх тал, 2012) Тодорхой, бодит шинж тэмдгийг илрүүлэн тогтоож чадаагүй байгаа боловч, тэр нь бодит /материаллаг/ ертөнц дэх амьд зүйлсийн оршин тогтнох, амьдрах чадварын ямар нэг илэрхийлэл болохыг хүлээн зөвшөөрөөд байгаа билээ. Тиймээс ч аюулгүй байдлын тухай ойлголт нь өнгөц хэлбэрээс шинжлэх ухааны үндэстэй гүнзгий ойлголт руу шилжиж байгаа билээ.

Урьд нь аюулгүй байдлыг ихэвчлэн улсын аюулгүй байдалтай холбон

үздэг байсан бол 1980-аад оноос “нийгмийн аюулгүй байдал”-тай, харин өдгөө гол төлөв хувь хүний, нийгмийн, төр улсын аюулгүй байдалтай холбон гурвалсан нэгдлийн холбоон дотор авч үздэг болсон байна. Өргөн утгаараа “аюулгүй байдал” гэдэг ойлголт нь аливаа нийгмийн иргэдэд өөрийгөө илэрхийлэх, хөгжих, соёлжсон ертөнцөд амьдрах нөхцлийг бүрдүүлж өгөхөд оршиж байна. Энэ үзэл бодлыг судлаачдын ихэнх нь дэмждэг бөгөөд аюулгүй байдал гэдэг нь нийгмийн янз бүрийн систем болон хувь хүн өөрийгээ эрчимтэй, үр ашигтай хөгжүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хүчин зүйл, нөхцөл шалтгааны цогц бүрэлдэхүүн гэж үзэж байгаа юм.

Зарим судлаач аюулгүй байдлын сөрөг нөлөө үзүүлэх боломж нь аливаа түгшүүр айдас бүрэн арилсан үлгэр жишээ нөхцөл гэж үзэж, ингэхдээ туйлын ба харьцангуй аюулгүй байдал гэсэн категорийг ашиглахыг санал болгодог. Туйлын аюулгүй байдал бол бүх хүн төрөлхтний мөрөөдөл, тэмүүлэл юм.

Харин харьцангуй аюулгүй байдал гэж хүн төрөлхтөн ухаарч, илрүүлж чадах боломжтой аюул занал бөгөөд уг аюул занал үүсэн бий болох нөхцөлийг арилгаж, түгшүүр айдасгүйгээр оршин тогтнох боломжийг хэлж болох юм гэж энэ чиглэлээр судалгаа хийдэг судлаачид тайлбарладаг.

Хувь хүний аюулгүй байдал гэдэг нь бие махбодь, оюун санаа, нийгмийн байдлаараа хүн бүрэн ая тухтай байдал хангагдсаныг хэлнэ.

Хувь хүний аюулгүй байдал гэж амьдрал, эрүүл мэнд, эд хөрөнгийнхөө төлөө өөрийгөө аюул, заналаас халхлах, чөлөөлөх, тэрчлэн иргэн хүний суурь үнэт зүйл болох хуульчилсан эрх, эрх чөлөөг хамгаалах улс, нийгэм, бие хүний чадвар, бэлэн байдал юм.

Судалгаанаас үзэхэд “аюулгүй байдал” гэдгийг ямар нэг систем, объектыг гадны хөнөөх хүчин зүйл, эсвэл тэдгээрийн нэгдлээс хамгаалах үйл явц гэж ойлгож болох юм. Гэхдээ төр, нийгэм, бие хүний



Хуульчлалын үндэс



МОНГОЛ УЛСЫН
ХАМГААГАГЧ
ХАМГААГАГЧ
ХАМГААГАГЧ

язгуур ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс нь оргүй хоосноос үүсэн бий болохгүй нь ойлгомжтой. Орчин үед “төр, нийгэм, бие хүний язгуур эрх ашиг, сонирхол” гэдэг ойлголтыг “үндэсний язгуур эрх ашиг” гэдэг ойлголт алгуур шахан түрж байгааг ч анхаарахгүй байж болохгүй.

Дээр дурьдсаныг нэгтгэн дүгнэж аюулгүй байдал гэдгийг дараах байдлаар буюу төр, нийгэм, бие хүний (иргэний) аюулгүй байдал гэдэг нь түүхэн тодорхой нөхцөлд гадаад, дотоодын бодит болон болзошгүй аюулаас үндэсний язгуур эрх ашиг найдвартай хамгаалагдсан байдал (Бор Ж., Чулуунбат В. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс, 63 дахь тал, 2012) гэж тодорхойлж болох юм.

Тэгвэл байгууллагын буюу институцын аюулгүй байдлыг хэрхэн авч үзэхээс цагдан хорих байрны аюулгүй байдлын тухай ойлголт урган гарна.

Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэх явцдаа хорих байгууллага нь дээрх зорилтуудыг хангахаас гадна хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдогчдын болон ажилтан алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хоригдогчдын зүгээс хорих байгууллагад гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зэрэг аюулгүй байдлаа хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл цагдан хорих үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь аюулгүй байдлыг хангах асуудал байх бөгөөд энэ нь цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдогчдын болон ажилтан, алба хаагчдийн аюулгүй байдлыг хангах замаар Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад тодорхой үүрэг хүлээдэг төрийн тусгай субъект мөн юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект болохын хувьд хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчийг

хорих, баривчлах (Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999), хоригдогчийн зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Манай орны зарим эрдэмтэн, судлаачид “цагдан хорих” гэдэг ойлголтыг эрх зүйн болон аюулгүй байдлын шинжлэх ухааны үүднээс тодорхойлсон байдаг. Тухайлбал, академич С.Нарангэрэл цагдан хорих гэдэг ойлголтыг “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэх мөрдөн байцаах, эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад, мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах таслан шийдвэрлэх арга хэмжээний нэг юм” (С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” 2 дахь хэвлэл, 552 дахь тал, 2008) гэж тодорхойлжээ.

Хууль зүйн ухааны доктор, профессор Б.Бат-Эрдэнэ “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлаж эрх чөлөөг нь хязгаарлах албадлагын арга хэмжээ мөн” (Б.Бат-эрдэнэ. “МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги”, 265 дахь тал, 2004) гэж тодорхойлсон байна.

Мөн хууль зүйн ухааны доктор Ц.Очгэрэл “Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах асуудлыг тусад нь орхигдуулах бус хорих байгууллагын үйл ажиллагааны нэг онцлог чиглэл, чухал объектын хувьд хорих ангитай хамтатган нэг зарчмаар хандан тулгамдаж буй асуудлын талаар судлах нь зүйтэй” (Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох нь, 2016) гэж тодорхойлсон нь мөн хорих байгууллагын аюулгүй байдалтай уяалдаа холбоотой гэдэгтэй санал нэг байна.

Хууль зүйн ухааны доктор, профессор Н.Гантулга “Цагдан хорих үйл ажиллагаа нь сэжигтэн, яллагдагчаас дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хэрэгжүүлж буй албадлагын өвөрмөц үйл ажиллагаа мөн” (Н.Гантулга. Хүний эрх ба хорих ял, 194 дэх тал, 2015) гэж тодорхойлсон. Иймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхээс ял шийтгүүлж хүчин төгөлдөр болсон хоригдогч нарыг хорих ангид хуяглан хүргэх хүртэл хугацаанд цагдан хорих байранд хорих ял эдлүүлдэг тул хорих байгууллагын аюулгүй байдалтай уяалдаа холбоотой гэж үзэж байна.

Манай улсын эрүүгийн хууль тогтоомжийн онцлогоос шалтгаалан хүндэтгэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагчийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу “Цагдан хорьж” мөрдөх, шалгах ажиллагааг явуулдаг төдийгүй эрүүгийн хуулийн тусгай ангийн дийлэнх зүйл анги нь хорих ялын санкцтай, хуульд заасан үндэслэлээр цагдан хорьж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах боломж ихтэй зэрэг нь цагдан хорих байрны аюулгүй байдлын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болдог.

Судалгаа шинжилгээний ажлыг практик талаас нь түлхүү судалж байгаа зарим судлаачид “Хорих анги, баривчлах, цагдан хорих байрны аюулгүй байдал”-ыг түүний үйл ажиллагааны онцлог, зорилго, зорилттой нь уялдуулан хорих анги, баривчлах байр, цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, ноцтой хор уршиг, учруулж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зорилгоор эрх, үүрэг бүхий субъектүүдээс хэрэгжүүлж буй тасралтгүй шинж чанартай арга хэмжээний цогц, оновчтой бүтэц бүрдэх явдал (Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2010) хэмээн үзэж болох талаар эрдэм шинжилгээний илтгэл, бүтээлүүддээ дурьдсан байдаг.

Цагдан хорих ажиллагааны явцад хорих байрны хэвийн үйл ажиллагааг хангах тухай ойлголтыг өнөөгийн жишигт нийцүүлж өргөн утгаар нь хорих байрны “Аюулгүй байдлыг хангах ажиллагаа” гэж ойлгож болох юм. Цагдан хорих байранд

аюулгүй байдлыг хангах ажиллагааг зохион байгуулахын тулд тухайн арга хэмжээний зорилго, ач холбогдол, зарчим, агуулгыг нь сайтар мэдэж хорих байрны онцлог, нөхцөл байдал тохируулан, бодит судалгаанд үндэслэн явуулах зүйтэй бөгөөд аюулгүй байдалд нөлөөлөх гадаад болон дотоод хүчин зүйлсийг тогтоож түүнд тохирсон арга хэрэгслээр зохион байгуулснаар зорилгоо бүрэн хангах юм.

Цагдан хорих байрны аюулгүй байдлын түвшинг албаны өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа, бүтэц, орон тоо, барилга байгууламж, бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, ур чадвар, хамгаалалтын хүч хэрэгсэл, нийгмийн болон байгалийн хүчин зүйл, удирдлага зохион байгуулалтын ажил, арга барил, эрсдэлийг урьдчилан тооцоолох, даван туулах чадвар, удирдах дээд шатны байгууллагын бодлого, шийдвэр зэрэг олон хүчин зүйлстэй холбон тайлбарлаж болох юм. Харин энэ бүгдийг хамгийн оновчтой арга хэрэгслээр уялдуулан зохион байгуулсны үр дүнд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, шуурхай таслан зогсоож чадсан байх нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний гол үр дүн болно.

Хорих байгууллагын аюулгүй байдал хэмээх ойлголтыг эрдэмтэн, судлаачид хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай нь уялдуулан судлан гаргасан байдгаас дурьдвал доктор Ц.Очгэрэл нь өөрийн бүтээлдээ “Хорих байгууллагын аюулгүй байдал гэж хорих байгууллагын гадаад, дотоод сөрөг нөлөөллөөс хамгаалагдах хэрэгцээ хангагдаж, аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх зорилт бүхий цогц арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, үйл ажиллагаагаа хэвийн тогтвортой явуулах, нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” (Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох нь, 2016) гэж тодорхойлжээ. Аливаа байгууллага, хүн, төр улсын аюулгүй байдлыг хангах онолын ухагдахууныг харьцуулан үзвэл хор



Хорих байрны аюулгүй байдал



МОНГОЛ УЛСЫН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
СҮДЛАЛ

аюулгүй байдлын талаарх тодорхойлолтууд нь агуулгын хувьд адил түвшинд аюулгүй байдлын тухай илэрхийлж, зөрчилдөхгүй байгаа нь харагдаж байна. Тухайлбал: Цагдан хорих байрны аюулгүй байдлын объект нь хүн буюу алба хаагч, хоригдогч, хорих байгууллага өөрөө байхын хажуугаар аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь аюул, заналыг зайлуулах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ байх, аюулгүй байдал нь тэдгээрээс хамгаалагдсан байх нөхцөлийг ойлгох тухай зарчмыг агуулсан байна.

Дээр дурьдсан байдлаас дүгнэн судлаачийн зүгээс цагдан хорих байрны аюулгүй байдал гэж “Цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар үйл ажиллагааг алдагдуулж, ноцтой хор уршиг учруулж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлж, хоригдогчийг хорих үйл ажиллагааг хэвийн явуулах аюулгүй орчин бий болсон байх явдал юм” гэж тодорхойлж байна.

Судлаачдын бүтээл туурвилд дүн шинжилгээ хийж, аюулгүй байдал судлалын үүднээс авч үзвэл цагдан хорих байрны аюулгүй байдал нь өөрийн гэсэн дараах онцлог шинжийг агуулж байна. Үүнд:

1. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах асуудал нь тусгайлан судлан шинжилвэл зохих судлагдахуун байх зүй тогтолтой.

2. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах асуудлын нэг гол цөм нь нийгмээс тусгаарлан хоригдож буй хүмүүсийн хувийн байдал юм. Тийм учраас цагдан хоригдогчид нь нэг талаас гэмт хэрэгт шалгагдаж буй гэм буруу нь тогтоогдоогүй иргэн, нөгөө талаас тодорхой хязгаарлалтад орсон сэтгэл зүйн байдал нь тогтворгүй байнгын тасралтгүй хяналт шаардагдсан хоригдогч юм.

3. Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад сэжигтэн, яллагдагчийг тусгайлсан стандарт бүхий орчинд нийгмээс тусгаарлан хорих, тэдгээрийн

зүгээс дахин гэмт хэрэг үйлдэх, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх шинжийг агуулдаг орчин байдаг.

4. Цагдан хорих байрны нөхцөл байдал байнга хувьсан өөрчлөгдөж байдаг нь түүний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй харгалзан үзэх хүчин зүйл болж байдгаараа онцлогтой.

Иймд цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах ажиллагааны үндсэн зарчим нь цагдан хорих ажиллагааны явцад түүнийг хэрэгжүүлэгч субъектүүдийн зүгээс баримталбал зохих хүний эрх, шударга ёсыг дээдлэх, хуулийг нэг мөр сахиулах зэрэг нийтлэг ашиг сонирхол, хэм хэмжээг хамгаалах, хүндэтгэх шинжийг агуулсан байдаг бол аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоо, бодлогыг илэрхийлсэн үзэл баримтлалын нэгдлийг суурь зарчимд оруулан ойлгож болох юм.

Аюулгүй байдлын бодлогын суурь зарчмыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Үндэсний аюулгүй байдлыг хангах зарчимд эх оронч үндэсний үзлийг дээдлэх, төр иргэний хамтын ажиллагаа, аюулгүй байдлын бодлого цогц байх, мэдлэгт суурилах, бодитой хандах, даяаршлын хүчин зүйлийг харгалзах (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010) хэмээн тодорхойлжээ. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхой дэс дараалал, харилцан бие биетэй зохицолдсон, нягт уялдаа холбоо бүхий цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээ буюу тогтолцоог зохион байгуулахдаа дараах тусгай зарчмыг баримтлах зүй тогтолтой байж болно гэж судлаачийн зүгээс үзэж байна. Үүнд:

1. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах зорилго, зорилтоо тодорхойлж, түүнд нийцсэн үйл ажиллагаа явуулах;

2. Аюулгүй байдал, хор уршиг учруулж болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг

тэргүүлэх шинж чанартайд тооцон хэрэгжүүлэх;

3. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах бүхий л цогц арга хэмжээ шуурхай, тасралтгүй шинж чанартай байх;

4. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, үйл ажиллагаанд инженер техникийн хэрэгсэл, бусад шинжлэх ухаан, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэх;

5. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны хүрээнд явагдаж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаа, хүч хэрэгслүүд нь хоорондоо нягт уялдаа холбоотой байх;

6. Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд нь гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалан уян хатан байх. Өөрөөр хэлбэл аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь цагдан хорих байрны онцлог нөхцөл байдлаас хамааралтай байх шаардлагатай. (Ц.Очгэрэл, Цагдан хорих төв байрны аюулгүй байдлыг хангах тогтолцоонд гүйцэтгэх ажлын эзлэх байр суурь, 2007)

Цагдан хорих байрны аюулгүй байдал нь байгууллагын оршин тогтнох, хөгжих хэрэгцээнд суурилсан байхын зэрэгцээ цагдан хорих үйл ажиллагаа тасралтгүй, амжилттай хэрэгжих явц, зорилгод сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар алдагдуулж, ноцтой хор уршиг учруулж болзошгүй аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээний үр дүнгээр илэрхийлэгдэх юм.

Тэгвэл цагдан хорих байгууллагын аюулгүй байдлын бүрэлдэхүүн болох алба хаагчийн аюулгүй байдал хэрхэн хангагдсан байдалд дүн шинжилгээ хийе. Учир нь аюулгүй байдал хангагдсан байдал алба хаагчийн ажлын сэтгэл ханамж, албаны болон хувийн хэрэгцээгээр тодорхойлогддог ойлголт юм.

Цагдан хорих байр, түүний албан хаагчийн аюулгүй байдлын түвшинг тогтоох зорилгоор ШШГБ-ын цагдан хорих байрын 321 алба хаагчаас судалгаа авсан юм.

График 1.

Албан үүргээ гүйцэтгэхэд ажиллах орчин нөхцөл шаардлага хангадаг эсэх

321 responses




График 2.




МОНГОЛЫН ХУУЛЬ ЗӨРХӨН ДЭГЭЭ



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Таны бодлоор хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад хамгийн их нөлөөлж буй эрсдэлтэй хүчин зүйл юу вэ?

321 responses



▲ 1/3 ▼

График 3.

Та цагдан хорих байрны алба хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад үнэлгээ өгнө үү?

321 responses




График 4.

Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн аюулгүй байдал хэрхэн хангагдсан гэж үздэг вэ?

321 responses





График 5.

Алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг сэтгэл зүйч шаардлагатай эсэх

321 responses



Дээрх судалгааны үр дүнгээс үзвэл алба хаагчдын аюулгүй байдлыг хангах ажиллагаа оновчтой биш, алба хаагчийн аюулгүй байдлын түвшин дундаас баг байгааг илтгэж байна. ШШГЕГ-аас авч хэрэгжүүлдэг алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, аюулгүйн тойрог тогтоох, алба хаагчдыг хүн нэг бүрийн тусгай хэрэгслээр хангах зэрэг нь алба хаагчийн аюулгүй байдлыг хангах бүрэн арга хэрэгсэл болж чадахгүй байна.

Мөн дан ганц хоригдол хоригдогчдоос үүдэлтэй эрсдэлт хүчин зүйлсээс гадна алба хаагч цалин хангамж, сэтгэл зүйн эрүүл мэнд, ажиллах орчин нөхцөлийн асуудал нь мөн алба хаагчийн аюулгүй байдлыг тодорхойлох хүчин зүйлсэд зүй ёсоор багтахыг судалгааны үр дүн давхар илэрхийлж байна.

Дүгнэлт

1. Аюулгүй байдлын тухай ойлголт нь аюулыг үүсгэгч эх сурвалжаасаа хамааран харилцан адилгүй байгаа тул аюулгүй байдлын түвшинг үнэлэх, судлах үйл ажиллагаанд тухайн аюулыг үүсгэгч эх сурвалж нь хамгаалагдвал зохих ашиг сонирхолд хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг судлан шинжилж хорих байрны аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хэрэглэх хэрэгтэй.

2. Байгууллагын аюулгүй байдал нь байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг, зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй ойлголт бөгөөд байгууллагын аюулгүй байдлыг хангах

ажиллагаанд тухайн байгууллагын ажилтан албан хаагчийн хэрэгцээг хангах буюу албан хаагчийн аюулгүй байдлыг хангах асуудал чухал байна. иймд Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах ажиллагааны үндсэн хэсэг бол алба хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг өөртөө агуулж байна.

3. Цагдан хорих байрны алба хаагчийн аюулгүй байдал нь алба хаагчийн эрх, ашиг сонирхолыг хангах төдийгүй цагдан хорих байрны чиг үүргийг хангах, байгууллагын ашиг сонирхолыг хангах ажиллагаатай зэрэгцэн орших тул дан ганц цагдан хорих үйл ажиллагаатай холбон тайлбарлаж болохгүй юм.

4. Цагдан хорих байрны харуул хамгаалалтын алба хаагчид хоригдол, хоригдогчидтой шууд харилцаанд өдөр тутам ордог. Цагдан хорих байрны алба хаагч халдлагад өртөх, хоригдогчтой хувийн харилцаа тогтоох, хоригдогчдын нөлөөлөлд автах зэргээс үүдэн сэтгэл зүйн хувьд гэмтэх эрсдэл өндөр байгаа нь судалгаанаас харагдаж байна.

5. Цагдан хорих байрны харуул хамгаалалтын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хүний эрх, хүний хэрэгцээний онол хандлагад суурилан хөгжүүлэх шаардлагатай бөгөөд явцуу утгаар авч үзэх, халдлага, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх байдлаар авч үзэх нь аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны цогц байдлыг



МОНГОЛЫН ХУУЛЬ
ХАМГААЛАХ
МОНГОЛЫН ХУУЛЬ



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

алдагдуулах, үр дүнгүй арга хэмжээг хэрэгжүүлэх үндэс суурь болж байна.

Санал

1. Орон нутаг дахь цагдан хорих байруудад сэтгэл зүйчийн орон тоог шинээр бий болгох;

2. Цагдан хорих төвд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулах, орон тоог нэмэгдүүлэх.

3. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “зөрчил гаргасан хоригдогчийн эргэлт авах эрхийг хязгаарлах” гэж нэмэлт өөрчлөлт оруулах саналыг дэвшүүлж байна.

4. Манай улсад хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж улмаар гэмт хэрэгт холбогдон хоригдох болсон нь цагдан хорих байруудын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал бодитойгоор бий болсон. Гэвч Монгол Улсын цагдан хорих байруудад хар тамхины төрлийн бэлдмэлийг илрүүлэх техник хэрэгсэл дутмаг байгаа тул алба хаагчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэн сургах, үнэрч нохой ашиглах ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

5. Цаашид техник, технологийн дэвшлийг цагдан хорих байр болгонд байршуулан хэрэглээнд нэвтрүүлснээр алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, тэдний ажлын ачааллыг хөнгөвчлөх нэг томоохон ажил болно гэж үзэж байна. Домофон системийг хэрэглээнд нэвтрүүлснээр Цагдан хорих байруудад нэгдсэн удирдлагын систем бүхий аюулгүй байдлын холбоо тогтоох боломжийг бүрдүүлэх нь зүйтэй гэж дүгнэж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. (n.d.). Retrieved from www.merriam-webster.com.

2. Б.Бат-эрдэнэ. “МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги”, 265 дахь тал. (2004). УБ.

3. Бельков О.А. Понятийно-категориальный аппарат концепции национальной безопасности, №3, стр 91. (1994). Москва.

4. Бор Ж. Чулуунбат В. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс, 51 дэх тал. (2012). УБ.

5. Бор Ж., Чулуунбат В. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс, 63 дахь тал. (2012). УБ.

6. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010). 4.

7. Н.Гантулга. Хүний эрх ба хорих ял, 194 дэх тал. (2015). УБ.

8. Прохожев А.А. Общая теория национальной безопасности. (n.d.). Retrieved from

[/https://www.studmed](https://www.studmed).

9. С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” 2 дахь хэвлэл, 552 дахь тал. (2008). УБ.

10. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. (1999). УБ.

11. Төмөрчулуун Г. Уламжлалт бус аюулын зарим асуудал. Монгол Улсын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ, 161 дэх тал. (2014). УБ.

12. Төрийн мэдээлэл эмхэтгэл 17 дахь хэвлэл. (2012).

13. Улаанхүү Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал, 69-70 дахь тал. (2014). УБ.

14. Хил судлал сэтгүүл, 73 дахь тал. (2015).

15. Хууль дээдлэх ёс сэтгүүл. (2010). 49.

16. Ц.Очгэрэл, Цагдан хорих төв байрны аюулгүй байдлыг хангах тогтолцоонд гүйцэтгэх ажлын эзлэх байр суурь. (2007). УБ.

17. Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох нь. (2016). УБ.

18. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь, 60 дахь тал. (1996). УБ.

19. Эрдэнэчимэг Б. Аюулгүй байдлын чиг хандлага өөрчлөлт, батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь, 10 дахь тал. (2016). УБ.